



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠐᠕ сарын ᠕᠕ өдөр

Дугаар А/᠕᠖.

Улаанбаатар хот

「 Хан-Уул дүүргийн 28 дугаар цэцэрлэгийн
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус цэцэрлэгийн эцэг эхчүүдээс хандивласан нийт 6,840,680.00 (зургаан сая найман зуун дөчин мянга зургаан зуун ная) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн 28 дугаар цэцэрлэг (Т.Сарантуяа)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 28 дугаар цэцэрлэг (Т.Сарантуяа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 16 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Хан-Уул дүүргийн 28 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, хүчин чадал	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны өртөг		Хандивлагч байгууллага
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Принтер	Epson13258	2024	сайн	ш	3	480,000.00	1,440,000.00	Эцэг эхчүүд
2	Аяга таваг угаагч	Beko	2024	сайн	ш	3	1,473,560.00	4,420,680.00	
3	Суурин компьютер	Asus2022	2024	сайн	ш	1	980,000.00	980,000.00	
Машин тоног төхөөрөмжийн дүн								6,840,680.00	Хандив
Нийт бүртгэх хөрөнгийн дүн								6,840,680.00	